

Аудит хийгдэх нэгж:  
Төрийн захиргаа удирдлагын хэлтэс

Огноо:  
2022.7.6

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

**ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН**

Аудитын нэр: Шилэн данс

Жил: 2022 оны эхний хагас жил

Улаанбаатар хот

2022 он

## Агуулга

1. ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ
2. ТАНИЛЦУУЛГА
3. АУДИТЫН ҮР ДҮН
4. ДҮГНЭЛТ
5. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

## **НЭГ. ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ**

Ашигт малтмал газрын тосны газрын даргын 2022 оны төлөвлөгөөний биелэлт, “Дотоод аудитын төлөвлөгөө”-ний дагуу шилэн дансны хөтлөлт, цахим санд байршуулсан мэдээлэлд ХШҮСХ-ийн мэргэжилтэн Л.Бадамханд дотоод аудит хийлээ.

Шилэн дансны тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг АМГТГ-ын даргын 2021 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн А/18 дугаар тушаалаар байгуулагдан ажиллаж байна.

Ашигт малтмал газрын тосны газрын шилэн дансны цахим санд мэдээлбэл зохих төсөв гүйцэтгэлийн 9 төрлийн мэдээлэл, хөрөнгө оруулалт, тэндер, худалдан авалтын 5 төрлийн мэдээлэл, бусад 6 төрлийн мэдээллийг бүрэн мэдээлсэн ба хуулийн хугацааг хоцроосон 1 мэдээлэл байршуулсан.

2021 оны 12 дугаар сард хийсэн дотоод аудитаар илэрсэн зөрчлөөс хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн зөрчил 11 гарч байсан бол эхний хагас жилийн байдлаар 1 болж буурсан үзүүлэлттэй байна.

Зөрчлийн тоо буурсан хэдий ч хуулийн хугацаанд мэдээлэх үүргээ биелүүлж ажиллах шаардлагатай байна.

## **ХОЁР. ТАНИЛЦУУЛГА**

Ашигт малтмал газрын тосны газрын шилэн дансны хөтлөлт, цахим санд байршуулсан мэдээлэлд дотоод аудит хийхдээ 2022 оны шилэн дансны цахим санд оруулсан мэдээлэл, агентлагын даргын 2022 оны эхний хагас жилийн А-76 ширхэг, Б-67 ширхэг тушаалтай танилцаж, аудитыг хийж гүйцэтгэсэн. Шилэн дансны цахим санд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан хэдий ч засвар хийх, нэмж мэдээлэл байршуулахад хугацаа хоцорсон төлөвтэй болж программ өөрчлөгддөг байна.

## **ГУРАВ. АУДИТЫН ДҮН**

Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журамд тус тус заасныг

бүрэн хэрэгжүүлж, Шилэн дансны нэгдсэн цахим санд 20 төрлийн мэдээллийг 73 удаа хандалт хийж хуулийн хугацаанд 72 мэдээллийг байршуулсан ба 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл (*Тухай бүр*)-ийг 4 сард хугацаа хоцроож мэдээлсэн.

Дээрх мэдээллийг тухай бүр PDF форматаар байршуулах үүрэгтэй ТЗУХ-ийн дотоод асуудал, нууц хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Алтан-Очир ажлаас чөлөөлөгдөж уг ажлыг хариуцах албан тушаалтан байхгүй байгаа учир хуулийн хугацаанд мэдээлээгүй байна. Мөн 2021 оны шилэн дансны дотоод аудитаар газрын даргын А/5 тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны 5 гишүүний мэдэгдэл, А/17 тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны 5 гишүүний мэдэгдэл, А/68, А/69, А-70 дугаар дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны 15 гишүүний мэдээллийг оруулаагүй зөрчил илэрсэнд зөвлөмж хүргүүлж 2022 оны 1 дүгээр улиралд багтаан нөхөж оруулах, цаашид мэдээлэл солилцож ажлын хэсэг нягт уялдаа холбоотой, ажиллах талаар зөвлөмж хүргүүлсэн хэдий ч хэрэгжээгүй байна.

Мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн А/57 дугаар тушаалаар байгуулагдсан сонгон шалгаруулалтын комиссын үнэлгээний хорооны гишүүд байнгын давтамжтай үнэлгээний хороонд ажилладаг бөгөөд тус гишүүдийг сонгон шалгаруулалтын үнэлгээний хороонд ажиллахад тухай бүр “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг үнэлгээний хорооны нарийн бичгээс авч шилэн дансны мэдээллийн санд оруулж байх талаар зөвлөмж хүргүүлж байна.

Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.7 дах заалт *Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт*, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйл *Хүний нөөцийн ил тод байдал*, “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 3.2.17 дах заалтын дагуу хавсралт 23-аар мэдээлдэг. Тус мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулах үүрэгтэй ТЗУХ-ийн хүний нөөц, жендерийн асуудал хариуцсан мэргэжилтэн Т.Болорцэцэгт 2021 онд зарим мэдээллийг ойлголтын буруугаас зөрүүтэй мэдээлсэн

байсанд заавар, зөвлөмж хүргүүлж ажилласнаар 2022 онд мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдээллэж ажилласан байна.

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (*тухай бүр*), нийт байршуулбал зохих 287,810,420 төгрөгийн 20 мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна. Агентлагийн даргын “Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх тухай” 2021 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн А/18 тушаалаар батлагдсан төлөвлөгөөнд тус мэдээллийг байршуулан ажиллаж байсан мэргэжилтэн бүтцээр өөрчлөгдсөн тул шинээр томилогдсон ТЗУХ-ийн эдийн засагч Д.Билгүүнд ажлын хэсгийн нарийн бичиг болон байгууллагын админы хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд заавар зөвлөмж хүргүүлж ажилласнаар тус мэдээлэл хуулийн хугацаанд бүрэн мэдээлэгдсэн байна.

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, (*Тухай бүр*) нийт байршуулбал зохих 908 мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн. Орлогын 41,754,320,763 төгрөг, зарлагын 42,232,318,615 төгрөгийн мэдээллийг ТЗУХ-ийн нягтлан бодогч Х.Чулуунцэцэг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан.

Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, (*Тухай бүр*) 41 мэдээллийг бүрэн мэдээлж хуулийн хугацаанд шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлж ажилласан байна.

## **ДӨРӨВ. ДҮГНЭЛТ**

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасан “*тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх*” гэсэн заалтанд нийцүүлж, агентлагийн даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэг чиг үүргээ хангалттай хэрэгжүүлсэн.

Мөн тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д “*Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна*” гэсэн заалтын дагуу цахим самбар байршуулж, нээлттэй ил тод мэдээллээр олон нийтийг чөлөөтэй танилцах боломжийг хангаж ажилласан байна.


Шилэн дансны цахим санд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан хэдий ч засвар хийх, өөрчлөлт оруулах, нэмж мэдээлэл байршуулахад хугацаа хоцорсон төлөвтэй болж программ өөрчлөгддөг. Энэ нь shilendans.gov.mn цахим хуудас төгс боловсронгуй бус байгааг харуулж байна. Тухайлбал:

- Дараа жилийн төсвийн төсөл (*Бүтэн жилээр*)
- Байгууллагын батлагдсан төсөв (*Бүтэн жилээр*)
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (*Бүтэн жилээр*) зэрэг мэдээллүүдийг жил бүрийн 1 сарын 10-ны дотор цахим хуудсанд байршуулдаг бөгөөд нэмэлт өөрчлөлт орсон тохиолдолд мэдээллийг нэмэх, засварлах боломжгүй байдаг. Мэдээллийн өөрчлөлтийг оруулсан тохиолдолд хугацаа хоцроосон төлөвтэй болсноор Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, үндэсний аудитын газар болон хөндлөнгийн хяналт шалгалтын байгууллагын шалгалтын үнэлгээнд сөргөөр нөлөөлдөг.

#### **ТАВ. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ**

1. Шилэн дансны мэдээлэл байршуулах эрх бүхий ажилтны үүрэг хариуцлагыг дээшлүүлж ажиллах. Мэдээллийг үнэн зөв, бодитой, хуулийн хугацаанд бүрэн гүйцэт шилэн дансны цахим хуудсанд байршуулж хэвших.
2. Заавар зөвлөмж авсан албан хаагчид зөвлөмжийг хэрэгжүүлж, мэдээллийг дотоод аудитын тайланд заасан хугацаанд нөхөж оруулах талаар анхаарч ажиллах.
3. АМГТГ-ын газрын даргын 2021 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн “Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх тухай” А/18 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн мэдээлэл солилцож, ажлын нягт уялдаа холбоотой ажиллаж, заавар, зөвлөмж авах.
4. Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийг хуулийн хугацаа хоцроох мөн бүрэн гүйцэт бус мэдээлэх зөрчлүүд удаа дараа давдагдаж байгаа тул ажлын хариуцлагыг дээшлүүлж, үнэн зөв мэдээлэхэд анхаарч, шаардлагатай тохиолдолд хариуцлага тооцож ажиллах.

5. Цаашид зөрчил гаргасан алдсан албан хаагчид хариуцлага тооцож ажилладаг байх.
6. Мэдээллийг нэмж оруулахад хугацаа хоцорсон төлөвтэй болж өөрчлөгдөх тул Сангийн яамны шилэн дансны мэдээлэл хариуцсан ажилтнаас асууж зөвлөгөө авах.

Танилцсан: АМГТГ-ын дарга  Л.Баярмандал

Хянасан:

ХШҮСХ-ийн дарга  Б.Будхүү

Боловсруулсан:

ХШҮСХ-ийн мэргэжилтэн  Л.Бадамханд

Танилцсан:

ТЗУХ-ийн дарга  Б.Дашпүрэв

ТЗУХ-ийн нягтлан бодогч  Х.Чулуунцэцэг

ТЗУХ-ийн мэргэжилтэн  Т.Болорцэцэг

ТЗУХ-ийн мэргэжилтэн  Д.Дарьхүү

ТЗУХ-ийн эдийн засагч  Д.Билгүүн

Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар:.....

.....  
.....  
.....

2022 оны 07 дүгээр сарын 6-ны өдөр